БАТЛАВ.

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х.БАТЖАРГАЛ

АТА12937 9116621 9024070582

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ХҮҮХДИЙН ШИРЭЭ, САНДАЛ, ХУВЦАСНЫ ШҮҮГЭЭ, ТОГЛООМЫН ТАВИУР, ВАНДАН САНДАЛ, БАГШИЙН ШИРЭЭ, САНДАЛ, БИЧГИЙН ШҮҮГЭЭ, ЭРХЛЭГЧИЙН ӨРӨӨНИЙ ШИРЭЭ, САНДАЛ, БИЧГИЙН ШҮҮГЭЭ" ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ АРГААР ХУДАЛДАЖ АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№ XIV.1.3.1.7/2025

/мянган төг/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт	Нэгжийн үнийн дээд хязгаар
Багц-1 /Дотоодын үйлдвэр/			
1	Хүүхдийн ширээ /3-4 настай/	Хүүхдийн ширээ нь MNS 0004:1987, MNS 3742:1984 стандартын шаардлага хангасан, хатаасан модон материалаар хийгдсэн байна. Хавтангийн зузаан нь 18мм-ээс багагүй, хүүхдийн эрүүл ахуйн шаардлагад нийцсэн. Хүүхдийн аюулгүй байдалд тохирсон, цайвар шаргал өнгөтэй байна. Хэмжээ:Урт1000*өргөн600*өндөр520мм, ширээний хөлийн доод талд шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвчтэй, хөлийг угсарч, салгах боломжтой байна /шалнаас 10-15 мм хөндий байх/. Ширээ нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	99.0
2	Хүүхдийн сандал /3-4 настай/	MNS 0004:1987, MNS 3742:1984 стандартын шаардлагад нийцсэн байна. Хатаасан модон материалтай, түшлэгтэй сандлын хэмжээ: 310х280х535мм, суудлын хэмжээ 300х250х280мм, түшлэгийг арагш 108 градусын налуутайгаар урт300* өргөн 200мм түшлэгтэй цайвар эсвэл модны өнгөөр хийсэн байна. Сандлын суудал болон арын түшлэг нь хотгор сууттай зузаан нь 9 мм, чанар, стандартын шаардлага хангасан хатаалт сайтай модоор хийгдсэн, суудал болон түшлэг хэсгийн ирмэг нь дугуй байна. Хүүхэд сандлыг өргөж явахад тохиромжтой, хөнгөн 1.5-2 кг байна. Суудал нь хүүхдийн хувцас гэмтээхгүйгээр хийгдсэн байна.	50.8
3	Хүүхдийн ширээ /4-5 настай/	Хүүхдийн ширээ нь MNS 0004:1987, MNS 3742:1984 стандартын шаардлага хангасан, хатаасан модон материалаар хийгдсэн байна. Хавтангийн зузаан нь 18мм-ээс багагүй, хүүхдийн эрүүл ахуйн шаардлагад нийцсэн. Хүүхдийн аюулгүй байдалд тохирсон, цайвар шаргал өнгөтэй байна. Хэмжээ:Урт1000*өргөн600*өндөр550мм, ширээний хөлийн доод талд шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвчтэй, хөлийг угсарч, салгах боломжтой байна /шалнаас 10-15 мм хөндий байх/. Ширээ нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	99.0
4	Хүүхдийн сандал /4-5 настай/	MNS 0004:1987, MNS 3742:1984 стандартын шаардлагад нийцсэн байна. Хатаасан модон материалтай, түшлэгтэй сандлын хэмжээ: 310х280х600мм, суудлын хэмжээ: 310х260х300мм, түшлэгийг арагш 108 градусын налуутайгаар урт 30 х өргөн 20см, цайвар эсвэл модны өнгөөр хийсэн байна. Сандлын суудал болон арын түшлэг нь хотгор сууттай зузаан нь 9 мм, чанар, стандартын шаардлага хангасан хатаалт сайтай модоор хийгдсэн, суудал болон түшлэг хэсгийн ирмэг нь дугуй байна. Хүүхэд сандлыг өргөж явахад тохиромжтой, хөнгөн 1.5-2 кг байна. Суудал нь хүүхдийн хувцас гэмтээхгүйгээр сайн өнгөлсөн байна.	50.8
5	Хүүхдийн хувцасны шүүгээ	Чанар, стандартын шаардлага хангасан тунгалаг лакан болон гоёлын ламинар, өнгөлгөөгөөр өнгөлсөн ДСП, МДФ, HDF шахмал модон хавтангаар хийгдсэн, эмжээр нь зориулалтын хуванцар материалаар хийгдсэн байна. 4 тасалгаатай (1 тасалгаанд 2 хүүхэд хувцас хийх зориулалттай, хаалгатай), малгай болон гутлын тавиур, хувцас өлгөх өлгүүрийн хэсэгтэй, тасалгаа тус бүр 2 ханандаа хувцасны өлгүүртэй байна. хавтангийн зузаан нь 18мм-ээс, шүүгээний ар 8мм-ээс багагүй зузаантай модон хавтан байна. Хэмжээ: урт 1400* өргөн300* өндөр1500мм. Шүүгээний доод талд шалнаас тусгаарлагч материалтай /шалнаас 10-15мм хөндий байх/. Тасалгаа бүр нь өлгүүрийн зориулалттай төмөр хөндлөвчтэй байна. Хаалга нь улбар шар, шар, ногоон, цайвар цэнхэр өнгөтэй, их бие нь цагаан өнгөтэй байна. Хаалга их биеийг сайн чанарын нугасаар бэхэлж, хаалганд зориулалтын бариул хийсэн байна. Олон улсын Е0, Е1 стандарт хангасан.	335.0

6	Тоглоомын тавиур	Том жижиг тоглоом өрөх зориулалт бүхий 6-8 тасалгааг агуулсан тавиуртай. Тавцангууд нь харилцан адилгүй хэмжээтэй байх бөгөөд аюулгүй байдлыг хангасан байна. Хэмжээ: урт1200* өргөн 300* өндөр1050мм. Олон улсын Е0, Е1 стандарт хангасан, 15-18 мм-ийн зузаантай, нягт сайтай, хүүхдийн сонирхол татахуйц өнгө, загвартай, модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Шүүгээний хөлийг шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Шүүгээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	278.0
7	Сургалтын хэрэглэгдэхүүний шүүгээ	MNS 3742:1984. Чанар, стандартын шаардлага хангасан тунгалаг лакан болон гоёлын ламинар өнгөлгөөгөөр өнгөлсөн ДСП, МДФ, HDF шахмал модон хавтангаар, эмжээр нь хуванцар материалаар хийгдсэн. 3 тавиуртай, дээд, доод тавиур 3 тасалгаатай, дунд тавиур 2 тасалгаатай. Хэмжээ: урт1300* өргөн350* өндөр1100мм. Шүүгээний эд ангиудын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. Шүүгээний доод талд шалнаас тусгаарлагч /шалнаас 10-15мм хөндий байх/ зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Шүүгээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Хавтан олон улсын Е0, Е1 стандарт хангасан.	200.0
8	Вандан сандал	Хүүхэд сууж хувцас солих зориулалттай. Модон материалтай тавцан болон тулгуур 30 мм зузаан, бат бөх, модны өнгөтэй тунгалаг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн лакаар лакдсан, сандлын буланг хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс дугуйруулсан, мөн сандлын хөлийг шалнаас хөндийрүүлсэн зориулалтын зөөлөвчтэй байна. Хэмжээ: урт1400* өргөн300* өндөр350мм.	55.5
9	Багшийн бичгийн шүүгээ	Хэмжээ: урт800* өргөн450* өндөр 2000мм. Чанар стандартын шаардлага хангасан тунгалаг лазан гоёлын ламинар, өнгөлгөөгөөр өнгөлсөн ДСП, МДФ, HDF шахмал модон хавтангаар, эмжээр нь PVC буюу зориулалтын хуванцар материалаар хийгдсэн байна. Уг материал нь хуурахгүй ус чийг нэвтрүүлдэггүй, халуун хүйтэнд тэсвэртэй байна. Шүүгээний эд ангиудын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. Хаалгыг сайн чанарын тайвшруулагчтай нугастай хийнэ. Шүүгээний хөлийг шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Шүүгээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Хавтан олон улсын Е0, Е1 стандарт хангасан байна.	330.0
10	Багшийн ширээ	Хэмжээ: урт1200* өргөн600* өндөр 750мм. Чанар стандартын шаардлага хангасан тунгалаг лакан гоёлын ламинар, өнгөлгөөгөөр өнгөлсөн ДСП, МДФ, HDF шахмал модон хавтангаар, эмжээр нь PVC буюу зориулалтын хуванцар материалаар хийгдсэн байна. Уг материал нь хуурахгүй ус чийг нэвтрүүлдэггүй, халуун хүйтэнд тэсвэртэй байна. Эд ангиудын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. Ширээ нь гурван ширхэг шургуулгатай, Ширээний хөлийг шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. ширээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Хавтан олон улсын Е0, Е1 стандарт хангасан байна.	361.0
11	Эрхлэгчийн ширээ	Ширээний хэмжээ: урт 1600* өргөн750* өндөр750мм байх ба олон улсын Е0, Е1 стандарт хангасан, 18 мм-ийн зузаантай, нягт сайтай, цайвар шаргал өнгөтэй, модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Ширээний эд ангиудын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. Ширээний хөлийг шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Ширээний тавцангийн голд урт600* өргөн400 мм-ийн хэмжээтэй хар өнгийн зөөлөвчийг сайн бэхэлж байршуулах, мөн компьютерын утас оруулах нүх гаргах бөгөөд нүхэнд зориулалтын таг хийсэн байна. Ширээ нь гурван ширхэг шургуулга бүхий дугуйтай шүүгээтэй байх ба ширээтэй ижил өнгө бүхий материалтай байна. Шургуулганд далд цоож хийсэн байна. Ширээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	494.2

12	Эрхлэгчийн өрөөний бичиг хэргийн шүүгээ	Бичиг баримт хадгалах зориулалттай шүүгээний хэмжээ: урт800*өргөн400* өндөр1800мм. Дээд хэсэг нь металл рам бүхий шилэн хаалгатай, 2 тавиуртай 3 тасалгаатай, доод хэсэг нь 1 тавиур бүхий 2 тасалгаатай байна. Олон улсын Е0, Е1 стандарт хангасан, 15-18 мм-ийн зузаантай, нягт сайтай, цайвар шаргал өнгөтэй, модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Шүүгээний эд ангиудын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. Хаалга сайн чанарын тайвшруулагчтай нугастай хийнэ. Шүүгээний хөлийг шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Шүүгээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	415.0
13	Угтвар ширээ	Ширээний хэмжээ: урт1600* өргөн 800* өндөр 750мм ба хоёр талаас нь суух зориулалтай тул тавцангийн дунд хэсгээр нэмэлт тушаа хийсэн байна. Тушааны өндөр 300мм байна. Ширээг олон улсын Е0, Е1 стандарт хангасан, 18 мм-ийн зузаантай, нягт сайтай, цайвар шаргал өнгөтэй, модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Ширээний эд ангиудын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх байхаар холбоно. Ширээний хөлийг шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Ширээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	250.0
Багц-2 /Импорт/ худалдан авах			
14	Багшийн сандал	Чанар стандартын шаардлага хангасан төмөр рамтай, түшлэгтэй, түшлэг болон суудал нь зөөлөвчтэй, хөл нь хуванцар хамгаалалттай, гарын түшлэггүй хар өнгөтэй байна. Хэмжээ урт420* өргөн420* өндөр 1-400-450мм, өндөр 2-900мм. Зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	77.4

____o0o___